



МОНГОЛЫН МЯНГАНЫ СОРИЛТЫН САН
MILLENNIUM CHALLENGE ACCOUNT - MONGOLIA



“УСГҮЙ НЭГ ӨДРИЙГ ТӨСӨӨЛЬЕ” СЭДЭВТ ЗОХИОН БИЧЛЭГИЙН УРАЛДААНЫ УДИРДАМЖ

ЗОРИЛГО

1993 оны НҮБ-ын Ерөнхий Ассамблейн хурлын шийдвэрээр жил бүрийн 3 дугаар сарын 22-ны өдөр дэлхий даяар Дэлхийн усны өдрийг тэмдэглэдэг. Энэ өдрийг тохиолдуулан усны үнэ цэнийг сурталчлан таниулах, усны асуудалд олон нийтийн анхаарлыг хандуулах зорилгоор Монголын Мянганы сорилтын сан Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газар, Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар болон Нийслэлийн боловсролын газартай хамтран Нийслэлийн 6 дүүргийн Ерөнхий боловсролын сургуулиудын 3-5 дугаар ангийн сурагчдын дунд **“УСГҮЙ НЭГ ӨДРИЙГ ТӨСӨӨЛЬЕ”** сэдэвт зохион бичлэгийн уралдааныг зохион байгуулна.

ХАМРАХ ХҮРЭЭ

Нийслэлийн Ерөнхий боловсролын нийт сургуулийн 3,4,5 дугаар ангийн сурагчид

ЕРӨНХИЙ ЗОХИОН БАЙГУУЛАГЧ

- Монголын Мянганы сорилтын сан,

ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛАГЧ

- Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газар;
- Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар;
- Нийслэлийн боловсролын газар



Нэг. СЭДВИЙН АГУУЛГА

“Усгүй нэг өдрийг төсөөлье” сэдвээр хүүхэд багачууд усгүй өдрийн амьдрал хэрхэн өрнөх талаарх сэтгэгдэл, өөрсдийн мэдрэмж төсөөллийг үгээр илэрхийлэн зохион бичлэг бичнэ.

Хоёр. ТАВИГДАХ ШААРДЛАГА

1. Зохион бичлэг сэдвийн агуулгад бүрэн нийцсэн байх;
2. Усны үнэ цэнийг өөрийн мэдрэмжээр илэрхийлсэн, сонирхолтой эшлэл зүйрлэл, дүрслэл агуулсан байх ;
3. Зохион бичлэгийн үгийн тоо 350-аас хэтрэхгүй байна. (гараараа цэвэрхэн гаргацтай бичнэ);
4. Зохион бичлэгийн хуудсанд бичигчийн товч танилцуулга орсон байх /сурагчийн нэр, сургуулийн нэр, хаяг, холбоо барих утасны дугаар, и-мэйл хаяг, шуудангийн хаяг/;
5. Хугацаа хожимдсон бичвэрийг шалгаруулалтад оролцуулахгүй.

Гурав. БҮТЭЭЛ ИРҮҮЛЭХ

Уралдаан үндсэн 2 шаттай явагдана.

I ШАТ

Зохион бичлэгийн эхний шатны шалгаруулалтыг сургууль тус бүр дээр шалгаруулна.

Эхний шат буюу зохион бичлэг хүлээн авах хугацаанд Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газраас дүүрэг тус бүрийн нэр бүхий Ерөнхий боловсролын сургууль дээр усны сэдвээр хичээл сургалтын үйл ажиллагаа зохион байгуулна. Сургуулийн нэрс, хичээлийн хуваарийг хавсаргав.

II ШАТ

Хоёрдугаар шатанд ирүүлэх зохион бичлэгийг эх хувилбараар “Вайрал Партнерс” ХХК-т хүргүүлэн авчрах, эсхүл сканнердсан хувилбарыг mca-communication@mca-mongolia.gov.mn хаягаар ирүүлнэ.

Дөрөв. ШАЛГАРУУЛАЛТ

Уралдаанд оролцсон бичвэрүүдээс нийт 20 шилдэг бүтээлийг шалгаруулна. Шилдэг 20 бичвэрийн эздийг дараах байдлаар урамшуулна.

1. Монголын МСС болон хамтрагч байгууллагуудын гарын бэлэг, өргөмжлөл
2. Шилдэг бичвэрүүдийг олон нийтэд танилцуулах видео контентод оролцох эрх

Тав. ХУГАЦАА

Зохион бичлэгийг хүлээн авах хугацаа: 2024.03.05 – 2024.03.20

Шалгаруулах хугацаа: 2024.03.25

Шагнал гардуулах үйл ажиллагаа: 2024.03.30

Жич: Шалгаруулалтад ирүүлсэн шилдэг бүтээлийг хэвлэн нийтлэх, цаашид өөр форматаар ашиглах, олшруулах эрхийг Монголын Мянганы сорилтын сан болон хамтрагч байгууллагууд эдэлнэ.

Шаардлагатай мэдээллийг Монголын Мянганы сорилтын сангийн Олон нийттэй харилцах багтай холбогдож тодруулна уу.

ФЭЙСБҮҮК: Монголын Мянганы Сорилтын Сан

УТАС: +976 99169558

И-МЭЙЛ: mcaworldwaterday@gmail.com

Монголын Мянганы сорилтын сангийн тухай

Монголын Мянганы сорилтын сан нь Монгол Улсын Засгийн газар, АНУ-ын Мянганы сорилтын корпорацын хооронд байгуулсан Мянганы сорилтын II Компакт гэрээний дагуу “Улаанбаатар хотын нийт ус хангамжийг нэмэгдүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж байна. Хөтөлбөр нь Компакт гэрээний санхүүжилтээр нийслэлийн хүн амын унд, ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашиглаж буй усны хэрэгцээг урт хугацаанд тогтвортой хангах, усны хомсдолоос сэргийлэх зорилготой бөгөөд ус хангамжийн шинэ эх үүсвэрийг байгуулах, хаягдал ус дахин боловсруулах, усны салбарын тогтвортой байдлыг хангах төслүүдийг хэрэгжүүлж байна.

ХАВСРАЛТ

Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын инженерүүдийн хичээл заах хуваарь

Д/д	Хичээл заах салбар	Дүүрэг	Хороо	Бие даасан ААН нэр	Хугацаа
1	ХҮТ-1	БЗД	16	44-р сургууль	Ш/11
2	ХҮТ-2	БЗД	30	97-р сургууль	Ш/11
3	ХҮТ-3	БЗД	3	33-р сургууль	Ш/11
4	ХҮТ-4	БЗД	6	84-р сургууль	Ш/11
5	ХҮТ-5	СБД	10	3-р сургууль	Ш/11
6	ХҮТ-17	БЗД	8	Амгалан сургууль	Ш/11
7	ЗТТ	БЗД	1	48-р сургууль	Ш/11
8	ЗТТ	БЗД	16	53-р сургууль	Ш/11
9	ХҮТ-6	ЧД	4	5-р сургууль	Ш/11
10	ХҮТ-7	ЧД	3	24-р сургууль	Ш/11
11	ХҮТ-8	СБД	5	6 р сургууль	Ш/11
12	ХҮТ-9	БГД	4	20-р сургууль	Ш/11
13	ХҮТ-10	ХУД	2	52-р сургууль	Ш/11
14	ХҮТ-18	ХУД	10	7-р сургууль	Ш/11
15	ТТТ	БГД	3	Шинэ 73 сургууль	Ш/11
16	ХҮТ-11	БГД	13	13-р сургууль	Ш/11
17	ХҮТ-12	БГД	15	40-р сургууль	Ш/11
18	ХҮТ-13	БГД	19	47-р сургууль	Ш/11
19	ХҮТ-13	БГД	7	78-р сургууль	Ш/11
20	ХҮТ-14	БГД	5	43-р сургууль	Ш/11

21	ХҮТ-15	СХД	15	ИЦсургууль-80	III/11
22	ХҮТ-16	СХД	29	153-р сургууль	III/11
23	ХҮТ-19	СХД	6	9-р сургууль	III/11
24	БТТ	СХД	9	67-р сургууль	III/11

Бэлтгэсэн: Б.Нарантуяа, Олон нийттэй харилцах мэргэжилтэн

Хянасан: Т.Баярмаа, Олон нийттэй харилцах асуудал хариуцсан захирал

Баталсан: Э.Энхгэрэл, Гүйцэтгэх захирал